



ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН
ИХ СУРГУУЛИЙН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2019 оны 04 сарын 24 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

Удирдах зөвлөлийн дарга
сонгох, томилох тухай

Монгол Улсын Боловсролын тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.7 дахь заалт, БСШУС-ын Сайдын 2019 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн А/202 дугаар тушаал, Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн дүрмийн 4.2, Удирдах зөвлөлийн дүрмийн 2.7 дахь заалт, Удирдах зөвлөлийн 2019 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн хурлын тэмдэглэл, Удирдах зөвлөлийн гишүүдийн нээлттэй санал хураалтын дүнг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Үүсгэн байгуулагчийн санал болгосноор Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Удирдах зөвлөлийн даргаар Удирдах зөвлөлийн гишүүн, УИХ-ын даргын Нийгмийн бодлогын зөвлөх Д.Бадарчийг сонгосугай.

ДАРГА

Д.БАДАРЧ





ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛИЙН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2019 оны 04 сарын 24 өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

Г
Удирдах зөвлөлийн дэд дарга, нарийн бичгийн
Даргыг сонгох, томилох тухай

БСШУС-ын Сайдын 2019 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн А/202 дугаар тушаал, Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн дүрмийн 4.2, Удирдах зөвлөлийн дүрмийн 2.8, 2.9 дэх заалтууд, Удирдах зөвлөлийн 2019 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн хурлын тэмдэглэл, Удирдах зөвлөлийн гишүүдийн нээлттэй санал хураалтын дүнг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Үсгэн байгуулагчийн санал болгосноор Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Удирдах зөвлөлийн дэд даргаар Удирдах зөвлөлийн гишүүн, БСШУСЯНЫ Дээд боловсролын бодлогын газрын даргын үүрэг гүйцэтгэгч Т.Амаржаргаланг сонгосугай.
2. Удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргаар ШУТИС-ийн Захиргаа, хүний нөөцийн газрын дарга Н.Ганзоригийг томилон ажиллуулсугай.

ДАРГА

Д.БАДАРЧ





ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛИЙН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2019 оны 04 сарын 24 өдөр

Дугаар 03

Улаанбаатар хот


Г Барилга, архитектурын сургуулийн лабораторийн
барилга барих газрыг шилжүүлэх тухай

Монгол Улсын Боловсролын тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.12.3, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.4, Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Удирдах зөвлөлийн дүрмийн 3.1.3 дахь заалт, Удирдах зөвлөлийн 2015 оны 09 тоот тогтоол, Удирдах зөвлөлийн 2019 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Барилга, архитектурын сургуулийн лабораторийн шинэ барилга барих байршлыг Баянзүрх дүүргийн 2-р хороонд байрлах Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн эзэмшил газарт шилжүүлсүгэй.
2. Лабораторийн барилгыг барихтай холбогдуулан мэргэжлийн байгууллагуудад холбогдох зөвшөөрлүүд хүсэх тухай саналыг хүргүүлэхийг Санхүү, хөрөнгө оруулалт эрхэлсэн дэд захирал /Л.Баяр-Эрдэнэ/, Барилга, архитектурын сургуулийн захирал /Э.Нинжгарав/ нарт тус тус даалгасугай.
3. Лабораторийн барилгын ажилд зарцуулагдах зардлын төрлийг шилжүүлэн, 2019 оны төсвийн тодотголд тусган хэлэлцүүлэхийг Хөгжлийн бодлого, төлөвлөлт эрхэлсэн дэд захирал /Б.Сүхбат/-д даалгасугай.

ДАРГА

Д.БАДАРЧ





ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛИЙН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2019 оны 04 сарын 24 өдөр

Дугаар 04

Улаанбаатар хот

ШУТИС-д эрдэм шинжилгээний хүрээлэн байгуулах тухай

Монгол Улсын Боловсролын тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.12.2 дахь заалт, Дээд боловсролын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь заалт, Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн 11.2.1 дэх заалт, Засгийн газрын 2016 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 194 дүгээр тогтоол, ШУТИС-ийн дүрмийн 3.3.2 дахь заалт, Удирдах зөвлөлийн дүрмийн 3.1.7 дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2018 оны 02 дугаар сарын 09-ны өдрийн А-5/432 тоот албан бичиг, Хууль зүй, дотоод хэргийн яамны 2018 оны 8 дугаар сарын 16-ны өдрийн 1-4/4075 тоот албан бичиг, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын 2018 оны 8 дугаар сарын 24-ний өдрийн хэг/1822 тоот албан бичиг, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2019 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн 1-1/1115 тоот албан бичиг, Боловсрол, соёл, шинжлэн ухаан, спортын яамны 2019 оны 4 дүгээр сарын 23-ны өдрийн 6/3290 тоот албан бичиг, Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Удирдах зөвлөлийн 2019 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Засгийн газрын 194 дүгээр тогтоолоор ШУТИС-д “Шинжлэх ухааны парк-Биотехнологи” (хуучнаар Хөнгөн үйлдвэрийн судалгаа, туршилт үйлдвэрлэл бизнесийн корпораци) балансаас балансад шилжүүлсэнтэй холбогдуулан тус байгууллагыг 2019 оны 5 дугаар сарын 01-ний өдрөөс Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн бүрэлдэхүүн “Шинжлэх ухааны парк-Биотехнологи” эрдэм шинжилгээний хүрээлэн болгон зохион байгуулсугай.

2. “Шинжлэх ухааны парк-Биотехнологи” эрдэм шинжилгээний хүрээлэнгийн гэрчилгээ, тамга тэмдгийг шинээр гаргуулах, удирдлагыг томилох, чиг үүргийг, үл хөдлөх болон холбогдох бусад эд хөрөнгө, орон тоо, цалингийн санг хууль тогтоомж, дүрэм журмын хүрээнд шилжүүлэн авах ажлыг Боловсрол, соёл, шинжлэн ухаан, спортын яам, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар болон холбогдох эрх бүхий төрийн байгууллагуудад хандан шийдвэрлүүлэхийг Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн захирал /Б.Очирбат/, Эрдэм шинжилгээ, хамтын ажиллагаа эрхэлсэн дэд захирал /Т.Намнан/, Санхүү, хөрөнгө оруулалт эрхэлсэн дэд захирал /Л.Баяр-Эрдэнэ/, Захиргаа, хүний нөөцийн газрын дарга /Н.Ганзориг/ нарт тус тус даалгасугай.

3. Засгийн газрын 194 дүгээр тогтоол, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамнаас өгсөн чиглэлтэй уялдуулан “Шинжлэх ухааны парк-Биотехнологи”-ийн хүрээлэнгийн үйл ажиллагааны чиглэл, дотоод бүтэц зохион байгуулалт, ШУТИС-ийн бүрэлдэхүүн, харьяа хүрээлэн, төвүүдийг судалгааны бусад нөөцтэй хэрхэн оновчтой зөв зохион байгуулах талаарх саналыг боловсруулан Удирдах зөвлөлөөр хэлэлцүүлэн шийдвэрлүүлэхийг Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн захирал /Б.Очирбат/, Эрдэм шинжилгээ, хамтын ажиллагаа эрхэлсэн дэд захирал /Т.Намнан/ нарт тус тус даалгасугай.

ДАРГА

Д.БАДАРЧ

